



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И мэйл: [ub@audit.gov.mn](mailto:ub@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)

2023.04.05

№

864

танай

-ны №

-т

БАЯНГОЛ, СҮХБААТАР  
ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2023 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ УЛС ТӨРИЙН  
НАМ, ЭВСЛИЙН УДИРДЛАГА  
ТАНАА

### Мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах аудитын тухай

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д “Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардаагдах зардлын дун нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргасан байна” гэж заасан. Нийслэл дэх Төрийн аудитын газар орон нутгийн хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвслийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

1. Мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргахдаа Төрийн аудитын тухай хууль, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн хүрээнд MNS 6817 : 2020 – Төрийн аудитын стандартын дагуу дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1.1 Улс төрийн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т заасан мөрийн хөтөлбөрт тусгахыг хориглосон заалтад нийцсэн эсэхийг хянах;
- 1.2 Улс төрийн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасанчлан Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарах зардлын дун нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэхийг хянах;
- 1.3 Тодруулах зүйлсийг тухай бүр мэдэгдэх бөгөөд аудитын явцад удирдлагаас нэмэлт мэдээлэл, тайлбар авах;
- 1.4 Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д заасны дагуу сонгуулийн мөрийн хөтөлбөр нь аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасан шаардлага хангаагүй дүгнэлт гарсан тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргах болон дээрхтэй холбоотой бусад чиг үүрэг хамаарна.

Нам, эвслээс ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд нийцсэн эсэх дүгнэлтийг 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн дотор тухайн шатны Сонгуулийн хороонд хүргүүлнэ.

2. Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу нам, эвслийн удирдлага дараах үүрэг хариуцлагыг хүлээж байна. Үүнд:

- 2.1 Нам, эвсэл нь мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар 04 дүгээр сарын 10-ны өдрөөс өмнө Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлсэн байх;
- 2.2 Нам, эвсэл нь сонгуульд оролцох хүсэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө илэрхийлэхдээ дээрх дүгнэлтийг гаргуулсан байх;  
*/Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйл, мөн зүйлийн 25.3.4, 25.4.4/;*
- 2.3 Нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл /энэхүү захидалын нэг ба хоёрдугаар хавсралт/ мөн мөрийн хөтөлбөрийн 2 хувийг хэвлэмэл байдлаар олшруулан, хувийг CD-нд буулган дугтуйнд хийж битүүмжлэлтэйгээр нийслэл дэх Төрийн аудитын газар /Соёлын төв өргөө Г корпус 6 давхар 615 тоот/-т хүлээлгэн өгнө. Дугтуйн дээр намын нэрийг гаргацтайгаар бичсэн байна.

Аудит гүйцэтгэх хугацаанд сонгуульд оролцох нам, эвсэл мөрийн хөтөлбөрийг шаардлагатай баримт, материалын хамт Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлэх, аудитын зорилгоор хүссэн нэмэлт тайлбар, мэдээллийг бичгээр баталгаажуулж өгөх, аудитын нотолгоог олж авах нөхцөл, боломжоор хангаж ажиллана уу.

Нам, эвсэл нь хуулийн дээрх зохицуулалтуудыг анхаарч мөрийн хөтөлбөрөө хуулийн хугацаанд нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх бөгөөд тус чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тухайн нам, эвслийг төлөөлэн шууд харилцах эрх бүхий албан тушаалтны мэдээллийг нотлох баримтын хамт ирүүлж, уг албан тушаалтан солигдох өөрчлөгдөх бүрд Нийслэл дэх Төрийн аудитын газарт албан бичгээр мэдэгдэж ажиллахыг хүсье.

Аудитыг хуулиар тогтоосон хугацаанд гүйцэтгэхэд харилцан хүлээсэн үүргээ хэрэгжүүлж хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Хавсралт.....хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Нийлэл дэх Төрийн аудитын газрын 2023 оны  
04 дугаар сарын 05-ний өдрийн 06 дугаар  
албан бичгийн нэгдүгээр хавсралт

**Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан дүгнэлт гаргахтай холбогдуулан 2023 оны Баянгол, Сүхбаатар дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс мөрийн хөтөлбөрийн талаар Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх мэдээлэл**

| № | Нам эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ | Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн тооцооллыг хийхдээ төсвийн төсөөллийг баримталсан эсэх (тийм, угүй) | Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн аль заалтад хамаарч буй | УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050”-н аль заалтад хамаарч буй, мөн аймаг, нийслэлийг хөгжүүлэх зорилтын (холбогдох заалтыг бичих) | Тайлбар |
|---|---|--|--|--|---------|
| 1 | 1   | 2  | 3  | 4  | 5       |
| 2 |   |  |  |  |         |
| 3 |   |  |  |  |         |

Жич:

- 2 дугаар баганад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тооцоолоходоо төсвийн төсөөллийг баримталсан эсэх
- 3 дугаар баганад тийм\* гэх тохиолдолд зардлын мөнгөн дүнг /тэрбум төгрөгөөр / бичих.

Мэдээллийг бэлтгэсэн \_\_\_\_\_ -ыг төлөөлж

Нам/эвслийн/нэр

(тэмдэг) \_\_\_\_\_ -ыг төлөөлж

албан тушаал

овог нэр

гарын үсэг

(тэмдэг) \_\_\_\_\_ -ыг төлөөлж

албан тушаал

овог нэр

гарын үсэг

20... оны ... сарын ... өдөр

Нийлэл дэх Төрийн аудитын газрын 2023 оны  
04 дугаар сарын 05-ний өдрийн 04 дугаар  
албан бичгийн хоёрдугаар хавсралт

**Баянгол, Сүхбаатар дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн талаар Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх мэдээлэл**

/сая төгрөгөөр/

| № | Нам эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээ | Шаардагдах зардлын нийт | Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэр болон зардлын дүн /он тус бүрээр/ |   |   |   |   |   |      |    |    |    |    |  | Тайлбар |
|---|--|-------------------------|---|---|---|---|---|---|------|----|----|----|----|--|---------|
|   |  |                         | 2023  |   |   |   |   |   | 2024 |    |    |    |    |  |         |
| 1 | 2  | 3                       | 4   | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10   | 11 | 12 | 13 | 14 |  |         |
|   | Нийт дүн   |                         |   |   |   |   |   |   |      |    |    |    |    |  |         |

Мэдээллийг бэлтгэсэн

-ыг төлөөлж

Нам/эвслийн/нэр

(тэмдэг)

-ыг төлөөлж

албан тушаал

гарын үсэг

(тэмдэг)

овог нэр

-ыг төлөөлж

албан тушаал

овог нэр

гарын үсэг

20... оны ... сарын ... өдөр